| 1.9.1.1 | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа | Санал өгсөн төслийн тоо | 2022 онд улсын хэмжээнд 6 норм, дүрэм, 5 стандарт, 12 журам, 3 зааварт санал өгсөн. | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгсөн байна. | Салбарын хэмжээнд дагаж мөрдөх дараах журмын төслүүдэд санал хүргүүлсэн. Үүнд:<br>- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын төсөлд 1 санал<br>- Нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журмын төсөлд 4 санал<br>- Аймаг, нийслэл дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журмын төсөлд 1 саналыг албан бичгээр хүргүүлсэн байна.<br>Мөн киоск машины үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал болон цаашид хийх нэмэлт хөгжүүлэлтийн санал, газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтэд шаардлагатай саналуудыг тус тус хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9.1.2 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Эрсдэлийн үнэлгээг үнэлсэн байдал | 2023 онд улсын хэмжээнд 7035 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. | **Жилийн эцэст:** Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна. | Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан Газар, геодези зураг зүйн салбарын хяналт шалгалтын обьектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийн үнэлгээг 171 обьектод хийсэн. | 100 |
| 1.9.1.3 | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулсан байдал | Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар 2023 онд улсын хэмжээнд 367 объектод хяналт шалгалт хийсэн. | **Жилийн эцэст:** Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг Засгийн газраар батлуулахад санал өгч, ГЗБГЗЗЕГ-тай хамтран ажилласан байна. | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд үнэлэгдсэн обьектуудаас 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулах 10 обьектыг сонгож ГЗБГЗЗЕГ-ийн даргаар жагсаалтыг батлуулахаар салбарын хяналтын газарт хүргүүлсэн. | 100 |
| **1.9.2** | **“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Салбарын хэмжээнд 4761 мод** | **2021 онд ГЗБГЗЗГ, Нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ нийт 3862 мод тарьсан.** | **“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд тайланг нэгтгэн гаргасан байна.** | **“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд 125 ширхэг мод тарьсан.** | **100** |
| 1.9.2.1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 110 ш мод | 2023 онд тус салбарын хэмжээнд хавар нийт 1886 мод тарьсанаас 1635 мод ургаж байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд хавар болон намрын мод тариалалтын өдрүүдэд Сайнцагаан сумын Төвд зам дагуу 10 нарс, Тайвань улсын хөрөнгө оруулалтаар мод тарьж байгаа талбайд мод усалгааны эко хувинтай 45 ширхэг хайлаас, шар хуайс, улиас, байгууллагын хашаанд 70 хайлаас нийт 125 ширхэг мод тарьсан бөгөөд усалгаа арчилгааг цаг тухайд нь хийж модны ургалт 95 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1/524 дүгээр албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | |
| 1.9.2.2 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зориулалтаар газар эзэмшүүлэх байршлыг тодорхойлж газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулах | Үйл ажиллагаа | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Мод үржүүлгийн зориулалтаар олгосон газрын тоо, хэмжээ | - | Шинээр тарьж, арчилж ургуулсан ой, модоор бүрхэгдсэн болон тохижилт хийсэн цэцэрлэгт хүрээлэн, гудамжны талбайн хэмжээ нэмэгдсэн байна. | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 10 сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 24 байршилд 384,41 га газрыг төлөвлөн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн газарт тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 18116 ширхэг мод тарьсан байна. | 100 |
| **1.9.3** | **"Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцох** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан.** | **"Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байна.** | **Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжлийн үндэсний чуулган"-нд тус Газрын дарга болон аймгийн Ерөнхий архитектор, Барилга хот байгуулалтын хэлтсийн 2 албан хаагчийн хамт оролцсон.**<br>**"Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа"-ны жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, тайланг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлсэн.** | **100** |
| 1.9.3.1 | "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа"-ны жилийн хүрээнд | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай | Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлаж, хэрэгжилтийг хагас, | Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил", ГЗБГЗЗЕГ-ын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах | | | газрын харилцаа"-ны жил болгон зарласан. | бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Хариуцлагатай газрын харилцаа"-ны жил болгон зарлаж, 2024 оны 01 дүгээр албан даалгавраар "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа" нэрэмжит жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээг баталсантай холбогдуулан албан даалгаварт тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийн суурь түвшин, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж "Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа" нэрэмжит жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 01 дүгээр улиралд баталсан. Дээрх төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан томоохон арга хэмжээнээс дурдвал:<br>- Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног 2023 онд 27 байсныг 3 хоногоор багасгаж дунджаар 24 хоногт шийдвэрлэж байна.<br>- Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр албан хаагчдын тэтгэмж урамшуулал, дэмжлэг, тусламжид 160,4 сая.төг-ийг байгууллагын төсвөөс, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, тоног төхөөрөмж шинэчлэхэд 596,3 сая.төг-ийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, 756,7 сая.төг-ийг зарцуулсан байна.<br>- 15 сумын фото мониторингийн хээрийн судалгаа хийхэд шаардлагатай 1,7 сая төгрөгийн багаж хэрэгслээр (жин, метр, самбар) сумдын Газрын даамлуудыг хангаж хүлээлгэн өгсөн.<br>- Тус аймгийн 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2018 онд боловсруулан батлуулсан ба уг төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын төсөв болох 750,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусган батлуулсан.<br>- 15 сумын багийн иргэдийн Нийтийн Хурал, 8 сумын малчдын зөвлөгөөн, 5 сумын "Нээлттэй хаалганы өдөрлөг" зэрэг үйл ажиллагааны үеэр нийт 2750 иргэнд газрын удирдлагын нэгдсэн систем www.egazar.gov.mn сурталчлан газрын кадастрын 890 гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан байна. Мөн 20 гаруй төрийн байгууллагын 160 гаруй албан хаагчдад газрын удирдлагын цахим системийг сурталчилж, заавар зөвлөмж өгч, 5 төрлийн гарын авлага тараасан.<br>"Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа" нэрэмжит жилийн хүрээнд төлөвлөсөн 40 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, тайланг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | |

**ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.1** | **Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ** | **Үйл ажиллагаа** | **Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн сангийн цахим үйлчилгээгээр** | **Байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг хөтлөх журам батлагдсан.** | **21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштатбай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийн** | **1:1000-ны масштабтай байр зүйн зурагт хийгдсэн өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр оруулан баяжилтын мэдээг ГЗБГЗЗЕГ-ын заавар зөвлөмжийн дагуу** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **хэрэглэгч байгууллага, иргэдийг хангах** | **Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн санг цахимаар шинэчлэх боломж бүрдсэн.** | **мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.** | **\\192.168.20.24\ серверт байршуулсан.** | |
| 2.1.1.1 | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | Үйл ажиллагаа | Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоо | 2023 онд ААН-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр АМХ-д хүлээлгэн өгсөн. | Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг хүлээн авч геопорталд мэдээллийг оруулж, хэрэглээнд гаргасан байна. | Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн 2.25км урт 0,4кВт-ийн шугамын гүйцэтгэлийн зургийг хүлээн авсан. | 100 |
| **2.1.2** | **Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1 систем** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн хэвийн ажиллагааг хангасан байна. Ази-Номхон далайн бүсийн геодезийн ажлын группд Монгол Улсын 6 GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын хэмжилтийн өгөгдлийг бэлтгэн илгээсэн байна.** | **Аймгийн төвд байрлах гравиметрийн сүлжээний 0039 цэг дээр статик хэмжилтийн туршилтын хэмжилт хийгдсэн.** | **100** |
| 2.1.2.1 | Геодезийн сүлжээний цэгийн солбицлыг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх судалгаа хийх | Үйл ажиллагаа | 1 цэг | Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор ITRF2020 солбицлын тогтолцоог ашиглахаар болсон. | **Эхний хагас жилд:** Аймгийн төвд байрлах гравиметрийн сүлжээний цэг дээр GNSS-ийн 12 цагийн хэмжилт хийж өгөгдлийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн төвд байрлах гравиметрийн сүлжээний 0039 цэг дээр 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 12 цагийн хэмжилт хийж өгөгдлийг ГЗБГЗЗЕГ-ын \\192.168.20.24\ серверт байршуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.3** | **Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ** | **Улсын болон орон нутгийн төсөв, үйл ажиллагаа** | **Монгол орны газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулж, хэрэглээнд гаргах** | **1:100000-ны масштабтай байр зүйн зурагт орсон газар зүйн нэрийн мэдээллийн санг бий болгосон.<br>42 сумын газар зүйн нэрийн мэдээллийн санг цэг, шугам, талбайгаар үүсгэсэн.** | **Геопортал цахим системд 2020-2021 онд гүйцэтгэсэн газар зүйн нэрийн мэдээллийн санг хүлээн авч нэрийн мэдээллийн системд оруулсан байна.** | **2020-2023 онд тус аймгийн 14 сумын газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх ажил хийгдсэн.<br>2024 онд Адаацаг сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд Геопорталд цахим системд засварлах ажлыг эрчимжүүлэх талаар аймгийн хэмжээний газар зүйн нэрийн .shp файлыг 1:100000-ны масштабтай зурагтай давхардуулан шалгаж .shp файлыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.** | **100** |
| 2.1.3.1 | Газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх | Үйл ажиллагаа | 1 мэдээллийн сан | 2021 онд Газар зүйн нэрийн мэдээллийн санг геопорталд оруулсан. | Геопортал цахим системд аймгийн хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийг засварлан оруулж, цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна. | Адаацаг сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлыг 2024 онд “Ханийн цав” ХХК гүйцэтгэж сумын ИТХ-аар хэлэлцүүлэх шатанд байна.<br>Тайланг хүлээн авсны дараа Геопортал цахим системд мэдээллийг оруулна. | 100 |
| **2.1.4** | **Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх** | **Үйл ажиллагаа** | **GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээ 200 цэг, тэмдэг** | **Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.** | **Цэг, тэмдэгтийн цахим санг хөтөлж, шаардлагатай цэг, тэмдэгтийг нөхөн сэргээсэн байна.** | **15 сумын төвийн 106 цэг тэмдэгтийн тооллогыг зохион байгуулж, Цэг тэмдэгтийн цахим санг шинэчилсэн.** | **100** |
| 2.1.4.1 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | Үйл ажиллагаа | GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний цэг, тэмдэгт | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2023 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн | 15 сумын төвийн 106 цэг тэмдэгтийн тооллогыг зохион байгуулсан. Тооллогоор 106 цэгээс 104 цэг тэмдэгт бүрэн бүтэн, Дэрэн, Өлзийт суманд тус бүр 1 цэг тэмдэгт устсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинэчлэлтийг хөтөлсөн байна. | Холбогдох сумдын засаг дарга нарт цэг тэмдэгт нөхөн сэргээх улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. | |
| 2.1.4.2 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээсэн цэгийн тоо | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар "Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх" журмыг баталсан. | Цэг, тэмдэгт нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээн авч, цэг, тэмдэгтийн мэдээллийг цахим санд оруулсан байна. | Дэрэн, Өлзийт сумдад тус бүр 1 цэг тэмдэгт устсан ба харьялах сумдын Засаг дарга нарт цэг тэмдэгт нөхөн сэргээх улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн цэг, тэмдэгт нөхөн сэргээх зардлыг 2025 оны дээрх сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусгуулсан. | 100 |
| **2.1.5** | **Хаягийн мэдээллийн системийг хөтлөх** | **Үйл ажиллагаа** | **Хаягийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа** | **Хаягийн мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Хаягийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.** | **2021 онд аймгийн хэмжээнд олгогдсон бүх нэгж талбарын хаягийн мэдээллийг мэдээллийн санд бүрэн оруулж дуусгасан ба хаягийн мэдээллийн системийн өдөр тутамын үйл ажиллагааг хангаж, шинээр олгогдсон газрын хаягийг системээр дамжуулан кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй боловч хаяг олгогдоогүй 113 нэгж талбар, шинээр өмчлүүлж эзэмшүүлсэн 65 нэгж талбарт шинэ хаяг олгож баталгаажуулсан.** | **100** |
| 2.1.5.1 | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх | Үйл ажиллагаа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг аймгийн ерөнхий архитектортай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, нэр олгогдсон, нэрэмжит | Аймгийн хэмжээний бүх нэгж талбарын хаягийг 2021 онд хаягийн мэдээллийн санд бүрэн оруулсан.<br>2024 онд аймгийн хэмжээнд шинээр нэмэгдсэн гудамж талбай байхгүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болгосон талбай, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна. | | |
| 2.1.5.2 | Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй болович хаяг олгогдоогүй нэгж талбарт Хаягийн мэдээллийн системээр хаяг олгож, баталгаажуулах, тус системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглах | Үйл ажиллагаа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | Хаяг олгогдоогүй нэгж талбаруудад хаяг олгож баталгаажуулсан байна | Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй болович хаяг олгогдоогүй нэгж талбарт хаягийн мэдээллийн системээр дамжуулан 113 хаяг олгож, баталгаажуулсан. 2024 онд шинээр өмчлүүлж эзэмшүүлсэн 65 нэгж талбарт шинээр хаяг олгож баталгаажуулсан. | 100 |
| 2.1.5.3 | Хаягийн өгөгдөл мэдээллийг засварлах, шинэчлэн зураглах ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээг засварлах | Үйл ажиллагаа | Зам, гудамж, орц гарц, гудамжны эхлэл, төгсгөлийн тоо | Хаягийн мэдээллийн систем | **Жилийн эцэст:** Батлагдсан ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээллийг засварласан байна. | Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээг шалгаж буруу буюу давхар хаяг олгогдсон 113 нэгж талбарын хаягийг засварласан. | 100 |
| **2.1.6** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа, урсгалт төсөв** | **Нийслэл, 21 аймаг** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржийн системийг нэвтрүүлсэн.** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | **Сумдын Газрын даамлуудад газрын биржийн систем болон Газрын төлбөр, татварын системтэй холбоотой мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөг өдөр тутам өгч, 3 удаа албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Тухайлбал:**<br>**- Газрын кадастрын системд газрын төлбөрийн 2024 оны нэхэмжлэл үүсээгүй нэгж талбаруудын төлбөрийн нэхэмжлэлийг бүрэн үүсгэх**<br>**- Сумын тухайн жилийн төлөвлөгөөнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлэхээр тусгагдсан газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **цахимаар зохион байгуулж ажиллах**<br>**- Газар эзэмших, ашиглах эрх шилжсэн болон шинээр газар эзэмшүүлж ашиглуулсан тохиолдолд газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг тухай бүр үүсгэж байх талаар тус тус чиглэл хүргүүлсэн.** | |
| 2.1.6.1 | Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн, системээс төлөлтийн мэдээлэл хүлээн авсан нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Хуульд заасан хугацаанд төлбөр, татварын ногдуулалтыг илгээх, төлөлтийн мэдээллийг тухай бүр хүлээж авсан байна. | Газар эзэмшиж ашиглаж байгаа хүчинтэй нэгж талбар бүрт газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг хуулийн хугацаанд нь үүсгэсэн.<br>Аймгийн хэмжээнд 7378 нэгж талбарт ногдуулалт үүсгэж 7139 нэгж талбарт тухайн жилийн газрын төлбөр 1,7 тэрбум төгрөгний нэхэмжлэл, өмнөх оны газрын төлбөрийн үлдэгдэл 638,2 сая төгрөгийн нэхэмжлэл үүссэн байна.<br>239 нэгж талбарын эзэмшигч татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, газар эзэмшигч нас барсан, регистрийн дугаар зөрүүтэй, ТИН дугаар бүртгэлгүй зэрэг шалтгааны улмаас нэхэмжлэл үүсээгүй байна.<br>Шинээр газар эзэмшүүлж, ашиглуулсан тохиолдолд газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг тухай бүр үүсгэсэн.<br>2024 онд газрын төлбөрийн орлого 2 тэрбум төгрөг орон нутагт төвлөрүүлэхээс 11 сарын байдлаар 1,3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.<br>Ашиглалтаар олгогдсон газрыг мэдээллийн санд бүртгэснээр газрын төлбөрийн орлого нэмэгдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.6.2 | Төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрхийн харилцаанд орж байгаа нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Үйлчилгээ үзүүлсэн тоогоор тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. | Газар эзэмших эрхээ барьцаалсан 264 нэгж талбарын төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж төлүүлж, цахим болон цаасан хувийн хэрэгт хавсаргасан. | 100 |
| 2.1.6.3 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Цахим системийн хэрэглээ | Газрын төлбөр, татварын систем | **Эхний хагас жилд:** Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжийг сурталчилсан байна. | Сайнцагаан, Сайхан-Овоо, Адаацаг, Дэлгэрцогт, Өндөршил, Хулд, Эрдэнэдалай, Өлзийт сумдын “Малчдын зөвлөгөөн”-ний үеэр болон аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр иргэд олон нийтэд Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжийн талаар сурталчлан гарын авлага тараасан. Байгууллагын фэйсбүүк хуудсанд газрын төлбөрөө гар утаснаасаа хэрхэн төлөх зааврыг постер хэлбэрээр бэлтгэж 3 удаа 30 хоногийн давтамжтайгаар байршуулсан. | 100 |
| 2.1.6.4 | Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд оруулах, масс үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Хот, тосгон, бусад суурин газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна.<br>**Жилийн эцэст:** Бүртгэсэн зах зээлийн үнийн мэдээллийг ашиглан масс үнэлгээ хийсэн байна. | Аймгийн төвийн сум болох Сайнцагаан сумын цахим биржид бүртгэгдсэн 2024 оны 229 зах зээлийн үнийн мэдээг Газрын үнэлгээний системд шинэчлэн оруулсан ба 2018 оноос хойш нийт 1157 газрын зах зээлийн үнийн мэдээг татаж үнэлгээний системд шинэчлэн оруулсан.<br>Хүчин зүйлсийн утгыг 4 төрлөөр хүрээлэн буй орчин, инженерийн дэд бүтэц, үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц гэсэн төрөл бүрээр нь шинэчлэн уншуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Системд оруулсан үнийн мэдээнд дүн шинжилгээ хийхэд мэдээлэл дутуу, алдаатай орсон зах зээлийн үнийн мэдээ байгаагүй болно. | |
| 2.1.6.5 | Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх; | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.<br>Нийт **80** иргэн, ААН-ийн мэдээллийг бүртгэсэн байна. | 100 |
| 2.1.6.6 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газарт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байна. | Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан **23 байршилд 38 удаа** дуудлага худалдааг цахимаар зохион байгуулсан ба 11 дуудлага худалдаа амжилттай болж, 27 дуудлага худалдаа үнэ төлөөгүй, оролцогчгүй зэрэг шалтгааны улмаас хүчингүй болсон. Танхимаар дуудлага худалдаа зохион байгуулаагүй.<br>Аймгийн хэмжээнд **15 байршилд төсөл сонгон** шалгаруулалтыг цахим биржээр Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу зохион байгуулсан.<br>Тус аймгийн дуудлага худалдааны орлогын дансанд (100080000967 Ду.Газрын дуудлага худалдааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орлого) газрын дуудлага худалдааны орлого, дэнчин, газрын суурь үнийг төвлөрүүлдэг. Газрын дуудлага худалдаа, газрын суурь үнийн орлого 200 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээс газрын дуудлага худалдаанаас 142,2 сая төгрөг, газрын суурь үнэ 64,9 сая төгрөг, нийт 207,1 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. | |
| 2.1.6.7 | Газрын биржийн цахим програм хангамжаар дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх | Үйл ажиллагаа | Эрх шилжсэн нэгж талбарын тоогоор үнийн мэдээ нэмж бүртгэнэ. | Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх боломжтой болсон. | Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна. | Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний худалдагдсан үнийг газар эзэмших, өмчлөх эрх шилжсэн тоогоор, санал болгож буй үнийг зарын дагуу судлан тухай бүр цахим биржид бүртгэж байна. Газрын цахим биржийн системд **283 зах зээлийн үнийн мэдээ** бүртгэсэн. | 100 |
| **2.1.7** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, өгөгдөл, мэдээлэл, цахим хавсралтыг үнэн зөв бүрдүүлэн, цахим системд тогтмол хяналт тавин ажиллаж байна.** | **100** |
| 2.1.7.1 | Сумдын газрын даамлуудын өмнөх онуудад үүсгэсэн нэгж талбарын хувийн хэрэгт хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нөхөн бүрдүүлэх, цэгцлэх, ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Засвардлагдсан нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэрэгт холбогдох журмын дагуу хяналт хийгдэж алдаа, дутагдал заварлагдаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Тус газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалаар Хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан 15 сумын нэгж талбарын цахим болон цаасан хувийн хэргийг тулган шалгах ажлыг зохион байгуулах удирдамжийг баталсан. Батлагдсан удирдамжийн дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7.2 | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн цахим архивын материалд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийн дагуу цахим хавсралтыг баяжуулах арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Засварлаж сайжруулсан цахим хавсралтын тоо | Системд бүртгэгдсэн өргөдлийн тоо | ГКМС-ийн өргөдлийн цахим хавсралтад хяналт шалгалт хийгдэж алдаа дутагдал засварлагдаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | түүврийн аргаар 15 сумын нийт 792 нэгж талбарын цахим болон цаасан хувийн хэргийг тулган шалгах хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлттэй холбоотой шаардлага хангаагүй сканнердсан-83, буруу материал оруулсан-12, материал дутуу оруулсан-539 зөрчил илэрсэн нь Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журмын 9.3 дахь заалтыг зөрчсөн ба дээрх зөрчлийг бүрэн арилгуулсан.<br>Хяналт шалгалтын талаарх нэгдсэн тайланг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ. | 100 |
| 2.1.7.3 | Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, танилцуулах аргах хэмжээг зохион байгуулах, орон нутагт цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Газрын нэгдсэн цахим систем /egazar.gov.mn/ | Цахим системийн хэрэглээ нэмэгдэж иргэд олон нийт Egazar.gov.mn хаягаас газартай холбоотой мэдээ, мэдээлал авах, цахимаар хүсэлт илгээдэг болж цахимаар илгээх хүсэлтийн тоог нэмэгдүүлсэн байна | 15 сумын багийн иргэдийн Нийтийн Хурал, 8 сумын малчдын зөвлөгөөн, 5 сумын "Нээлттэй хаалганы өдөрлөг" зэрэг үйл ажиллагааны үеэр нийт 2750 иргэнд газрын удирдлагын нэгдсэн систем www.egazar.gov.mn сурталчлан газрын кадастрын 890 гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан байна. Мөн 20 гаруй төрийн байгууллагын 160 гаруй албан хаагчдад газрын удирдлагын цахим системийг сурталчилж, заавар зөвлөмж өгч, 5 төрлийн гарын авлага тараасан. | 100 |
| 2.1.7.4 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан | Үйл ажиллагаа | Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо | Газрын кадастрын мэдээллийн санд нийт бүртгэсэн өргөдөл | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим | Аймгийн хэмжээнд газрын удирдлагын нэгдсэн систем www.egazar.gov.mn кадастрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | | | | системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан байна. | цахим системээр дамжуулан нийт 1061 цахим хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. | |
| 2.1.7.5 | Нийт сумдын 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах | Үйл ажиллагаа | Захирамжийн тоо, нөхөн бүртгэж оруулсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй нэгж талбарын тоо | Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргасан байна. ГКМС-д нөхөн бүртгэх арга хэмжээ бүрэн дууссан байна. | Аймгийн хэмжээнд 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр бүрт хяналт хийж мэдээллийн сан үүсгэсэн. Захирамжийн бүртгэлийг ГКМС-тай тулгаж, мэдээллийн санд бүртгэгдээгүй 104 нэгж талбарыг газрын кадастрын цахим системд оруулсан. | 100 |
| 2.1.7.6 | Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх | Орон нутгийн төсөв | Аймаг, сумдад шинээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо | Улсын хэмжээнд 2022 оноос эхлэн нийт 21 төхөөрөмжийг нэвтрүүлсэн. | Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна. | Аймгийн хэмжээнд 2 байршилд 2 киоск машин байршуулсан. Киоск машинаар дамжуулан газрын харилцаатай холбоотой 70 гаруй төрлийн үйлчилгээг давтагдсан тоогоор 5000 гаруй иргэнд үзүүлсэн байна. | 100 |
| 2.1.7.7 | Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээнээс төлбөр тооцох боломжийг бүрдүүлж холбогдох байгууллагатай гэрээ байгуулж ажиллах | Үйл ажиллага | Холбогдох байгууллагатай хийсэн гэрээ | 2023 онд төлбөр тооцох хөгжүүлэлтийг гүйцэтгсэн. | Холбогдох байгууллагатай гэрээ байгуулж Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээ төлбөртэй болсон байна. | Киоск төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээнээс төлбөр тооцох боломжийг бүрдүүлж "ККТТ" ХХК-тай гэрээ байгуулж, газрын харилцаатай холбоотой үйлчилгээ төлбөр авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. | 100 |
| 2.1.7.8 | Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, өгөгдөл, мэдээлэл, цахим хавсралтыг үнэн зөв бүрдүүлж ажиллах | Үйл ажиллагаа | Системийн хэвийн үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн систем | ГКМС-ийг холбогдох журам, зааврын дагуу өгөгдөл мэдээллийг үнэн зөв бүртгэж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. | Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, өгөгдөл, мэдээлэл, нэгж талбарын хувийн хэргийн цахим хавсралтыг үнэн зөв бүрдүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 2.1.7.9 | ГКМС-д бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж буруу, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах, сайжруулах, шинээр ОНТХ-нд авсан газрыг бүртгэж баталгаажуулах | Үйл ажиллагаа | Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо | - | **Жилийн эцэст:** Аймаг, сумдын хэмжээнд ОНТХ-нд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн судалгааг гаргаж ГКМС-д бүртгэгдсэн мэдээлэлд нэг бүрчлэн хяналт хийж, илэрсэн алдаа дутагдлыг засварласан байна. Шинээр авсан газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулсан байна. | 15 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2003-2024 оны тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрыг аймаг, сумын ИТХ-аас баталсан тогтоолуудтай тулгалт хийж, мэдээллийн санд дутуу болон буруу зөрүүтэй орсон 186 газрын мэдээллийг засварлаж тайланг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/416 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. | 100 |
| 2.1.7.10 | Газрын нэгдмэл сангийн цахим системийн өгөгдөл, мэдээлэлд хяналт хийж, алдаатай, зөрүүтэй оруулсан мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим системийн мэдээлэл засварлагдсан байна. | Аймгийн хэмжээнд 2003-2023 онд газар олгосон эрх зүйн актыг газрын кадастрын мэдээллийн сантай тулгах ажлын хүрээнд 327 нэгж талбарын зориулалт, топологийн алдаа зэрэг зөрүүтэй оруулсан мэдээллийг засварласан. | 100 |
| 2.1.7.11 | Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчилтэй нэгж талбарын давхаргад хяналт хийж зөрчил арилсан мэдээллийг шинэчлэх, одоо байгаа болон шинээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн систем | Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна. | Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчилтэй нэгж талбарын давхаргад хяналт хийж зөрчилтэй байсан 183 нэгж талбарын мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу кадастрын мэдээллийн санд баталгаажуулж зөрчлийг арилгасан. | 100 |
| **2.1.8** | **Салбарын хэмжээнд сүлжээ, техник, програм хангамж, системийн хэвийн, аюулгүй,** | **Үйл ажиллагаа, урсгал төсөв,** | **Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа,** | **Байгууллагын дотоод сүлжээ домэйн удирдлагын системд холбогдсон.** | **Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник,** | **Байгууллагын сүлжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмж болон мэдээллийн систем, програм хангамжийн** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **найдвартай үйл ажиллагааг хангах** | **хөрөнгө оруулалт** | **Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа** | **21 аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. Мэдээллийн аюулгүй байдлын газрын Төрийн хамгаалагдсан нэгдсэн сүлжээнд холбогдсон. Байгууллага, нийслэл, 21 аймаг, 345 цэг /сум, суурин, GNSS БАС/ интернэтийн сүлжээнд холбогдсон.** | **хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.** | **хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна.** | |
| 2.1.8.1 | Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байгууллагын сүлжээний төхөөрөмж болон Газрын даамлуудын VPN тусгаарласан сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байдал | Аймаг, сумд интернэтийн сүлжээнд холбогдсон. | **Эхний хагас жилд:** Нийт сумдын Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын төхөөрөмж (Гэр интернэт)-ийг шинэчлэх ажлыг зохион байгуулаж, хэвийн ажиллагаанд оруулсан байна. **Жилийн эцэст:** Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангасан байна. | Байгууллагын дотоод сүлжээ болон ГЗБГЗЗЕГ-тай холбогдсон тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын VPN сүлжээ, хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станц, сумдын даамлуудад ашиглагдаж буй гэр интернет төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, шаардлагатай тохиолдолд ГЗБГЗЗЕГ-ын Мэдээлэл технологийн хэлтэс болон Unitel-тэй холбогдож, арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулж ажилладаг.<br>2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс сумдын Газрын даамлуудад ашиглагдаж байсан гэр интэрнетийг шинэчлэн өөрчилсөн бөгөөд хуучин гэр интэрнетийг татан авч шинэ гэр интернэтийг хүлээлгэн өгөх ажлыг цаг хугацаанд нь зохион байгуулсан. | 100 |
| 2.1.8.2 | Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, | Үйл ажиллагаа | Техник, хэрэглээний програм хангамжийн | Асуудал гарсан тухай бүрд техник засвар үйлчилгээг цаг алдалгүй | - Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн хэвийн, | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/160 дугаар тушаалаар батлагдсан "Салбарын мэдээллийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах | | хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа | хийж хэвийн ажиллагааг хангасан. Байгууллагад хэрэглэгдэж буй бусад техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, ажиллагааг хангаж ажилласан. | тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна. - Байгууллагад хэрэглэгдэж буй хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан байна. | технологийг ашиглах дотоод журам"-ын дагуу байгууллагад ашиглагдаж буй компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжүүдэд бүртгэл үүсгэн, эвдрэл гэмтэл, хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд засвар үйлчилгээг хийн тухай бүр техник хангамжийн карт хөтлөн ажилладаг. Техник хангамжийн картын бүртгэлд 15 компьютер бүртгэн үйлдлийн системийг шинэчилж, шаардлагатай программ хангамжийг суулгасан. Мөн сэлбэх шаардлага үүссэн 9 компьютерт hard болон ram нэмэлтээр суурилуулан компьютерын ажиллах хүчин чадлыг нэмэгдүүлсэн. | |
| **2.1.9** | **Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд шаардлагатай веб хуудас, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх хэрэглээнд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа, урсгал төсөв** | **3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт** | **8 веб хуудас хэрэглээнд гаргасан.** | **3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн саналыг нэгтгэн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2/493 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.** | **100** |
| 2.1.9.1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем /Геопортал/-ийн дэд санг стандартын дагуу бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Дэд сан бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн тоо | 2023 онд Геопорталд дэд сан бүрээр өгөгдөл бүрдүүлсэн. | Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрдүүлсэн байрлалд суурилсан мэдээллийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геопортал)-д 18 дэд сангийн стандартын дагуу баяжуулж, бүрдүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-аас 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан "Хот байгуулалтын кадастрын цахим систем"-ийн сургалтад тус байгууллагын 2 албан хаагч хамрагдсан. 2024 онд ашиглалтад орсон Сайнцагаан сумын "Түмний хороолол" болон "Хаус хороолол"-ын гадна 1,8 км ариутгах татуургын шугам, Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн 2.25км урт 0,4кВт-ийн шугам, хүн оршин суудаг газраар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өнгөрөх 10 хүртлэх кВт 63,6 км урттай цахилгаан дамжуулах инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зураглалыг “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-д оруулсан. | |
| **2.1.10** | **Салбарын архивын баримтаар хэрэглэгчдэд үйлчлэх** | **Үйл ажиллагаа** | **Цаасан болон цахим баримтын үйлчилгээ** | **108 хадгаламжийн нэгжийн баримтаар үйлчилгээ үзүүлсэн.** | **Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.** | **Тухайн жилд цаасан баримтаар дотоод ажлын хэрэгцээнд 55 удаа, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 67 удаагийн лавлагаа мэдээлэл өгч үйлчилсэн.** | **100** |
| 2.1.10.1 | Архивын баримтаар байгууллага, иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох | Үйл ажиллагаа | Ирүүлсэн хүсэлтийн дагуу үзүүлсэн үйлчилгээний тоо, төрөл | 2023 онд архивын баримтаар 108 хадгаламжийн нэгжийн баримтаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэн болон байгууллагын дотоодын үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлсэн. | Ирүүлсэн хүсэлтийн дагуу цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна. | Байгууллагын архивт хадгалагдаж буй баримтаар иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэн архиваас олгосон баримтын хуулбарын бүртгэл, дотоод ажлын хэрэгцээнд ашиглуулахаар олгосон баримтын бүртгэлийг тогтмол хөтөлдөг.<br>2024 онд цаасан баримтаар дотоод ажлын хэрэгцээнд 55 удаа, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 67 удаагийн лавлагаа мэдээлэл өгч үйлчилсэн. | 100 |
| **2.1.11** | **Төрийн архивын стандарт орчныг сайжруулах** | **Үйл ажиллагаа** | **Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа** | **-** | **Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.** | **Архивын өрөөг стандартын дагуу тохижуулан өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.** | **100** |
| 2.1.11.1 | Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах талаар санал тавьж шийдвэрлүүлэх | Үйл ажиллагаа | Саналын тоо | Жил бүр архивын стандарт орчныг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг. | **Эхний хагас жилд:**<br>Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын | Тус байгууллага нь өмнөх онуудад архивын 6 ширхэг нягтруулсан шүүгээг 15 сая төгрөгөөр худалдан авч байршуулсан ба архивын өрөөг стандартын дагуу тохижуулсан.<br>Байгууллагын архивын ажлын үндсэн зааварт заасны дагуу архивын өрөө тасалгаанд 7 хоног | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцоо гарган удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авсан байна. | бүр агаар сэлгэлт хийж, чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийдэг. Цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэлийг тухай бүр хөтөлдөг. | |
| **2.1.12** | **Геодезийн хэмжилтийн багаж баталгаажуулалтын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах** | **Үйл ажиллагаа** | **Баталгаажуулсан багажны тоо** | **2022 онд улсын хэмжээнд 1 багаж баталгаажуулсан.** | **2023 онд аймгийн хэмжээнд 1 багажийг баталгаажуулсан байна.** | **Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 2 долгионы GNSS-ийн хүлээн авагч багажийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталгаажуулж гэрчилгээ авсан.** | **100** |
| 2.1.12.1 | Аймгийн ГХБХБГ-т хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах | Үйл ажиллагаа | 1 багаж | 2023 онд аймгийн ГХБХБГ-т хэрэглэж байгаа нийт 1 багаж баталгаажуулалт хийлгэсэн. | 2023 онд баталгаажуулалт хийлгэсэн хугацаанд, бүх багажуудыг бүрэн хамруулсан байна. | Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 2 долгионы GNSS-ийн хүлээн авагч багажийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталгаажуулж гэрчилгээ авсан. | 100 |
| **2.1.13** | **Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах** | **Үйл ажиллагаа** | **Иргэн, хуулийн этгээдийн тоо** | **2023 онд иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах талаар 12 объектыг төлөвлөгөөт шалгалтад хамруулсан.Тус шалгалтаар эрсдэл үүсэх магадлалын 32% байсан.** | **Эрсдэл үүсэх магадлалыг бууруулсан байна** | **2024 онд төлөвлөгөөт шалгалтад 4 обьект, төлөвлөгөөт бус шалгалтад 15 иргэн, аж ахуй нэгжийг хамруулсан ба эрсдэл үүсэх магадлалын дундаж 29 хувь болж өмнөх оноос 3 хувиар буурсан байна.** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.13.1 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Сумдаас ирүүлсэн зөрчилтэй газрын судалгааны дагуу нийт 11 иргэний газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах талаар Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлага биелүүлээгүй 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх заалтын дагуу торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийн үр дагаварыг арилгуулах албан даалгавар хүргүүлсэн. | 100 |
| 2.1.13.2 | Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Газрын даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу нийтийн эзэмшлийн газрыг зөвшөөрөлгүй ашиглаж байсан 1 иргэн, 1 ААНБ-д илэрсэн зөрчлийг арилгуулах талаар Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж газрыг чөлөөлсөн. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газар ашигласан 1 иргэнийг Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлүүлсэн. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу "Тэвшийн говь" ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж илэрсэн 2 зөрчлийг арилгуулахаар хамтарсан албан шаардлага хүргүүсэн. | 100 |
| 2.1.13.3 | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах | Үйл ажиллагаа | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн | - | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн | Зөрчлийн талаарх 3 гомдол мэдээллийг байгууллагын болон прокурорын нэгдсэн бүртгэлд хуулийн хугацаанд бүртгүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тоо | | дагуу арга хэмжээг авсан байна. | Дээрх 3 гомдол мэдээллийн 1 гомдол мэдээлэлд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1.5 дахь заалтыг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахаас татгалзсан. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1<br>Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.** | | | | | | | |
| **3.1.1** | **Газар зүйн нэрийн тодруулалт** | **Улсын болон орон нутгийн төсөв** | **Нэрийн тодруулалт хийх аймаг, сумын тоо** | **2023 онд 11 аймгийн 35 сум, нийслэлийн 1 дүүрэг газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийсэн.** | **Нэрийн тодруулалт хийх ажлын төсөв батлагдсан аймаг, сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж, мэдээллийн сан байгуулна.** | **2024 онд Адаацаг сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 12 сая төгрөгийн хөрөнгөөр хийсэн.** | **100** |
| 3.1.1.1 | Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | Урсгал төсөв | 2 хурал | 2023 оны Газар зүйн нэрийн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. 4 удаа газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, 1 удаагийн хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлын | Тус аймгийн 1 сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөл хуралдаж сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг гүйцэтгэгч "Ханийн цав" ХХК-д ажил эрчимжүүлэх талаар чиглэл хүргүүлсэн.<br>Мөн Дэрэн сумын газар зүйн нэрийн зөвлөл хуралдаж сумын хилийн эргэлтийн цэгийг тогтоолгох талаар хүсэлт ирүүлснийг шийдвэрлэж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | | |
| **3.1.2** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэг** | **2022 онд Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэгт бэлчээрийн фотомониторингийн ажлыг зохион байгуулсан.** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 320 сумын хэмжээнд бэлчээрийн газрын 5166 мониторингийн цэгт хийсэн байна.** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд 247 цэгт 08 дугаар сарын эхний 10 хоногт зохион байгуулсан.** | **100** |
| 3.1.2.1 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах | Үйл ажиллагаа | Аймгийн хэмжээнд байгуулсан мониторингийн цэгийн тоо | 2023 онд 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн бэлчээрийн газарт фото мониторингийн ажлыг зохион байгуулагдсан. | **Жилийн эцэст:** 2024 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргаж, газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 10 сарын 01-ны дотор хүргүүлсэн байна. | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг 15 сумын хэмжээнд 08 дугаар сарын эхний 10 хоногт багтаан 247 цэгт хээрийн судалгааны ажлыг зохион байгуулж, боловсруулалтын ажлыг гүйцэтгэн газрын мониторингийн цахим системд мэдээллийг бүрэн оруулж, тайланг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 02/395 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| 3.1.2.2 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам, арга зүйг сайжруулах талаар санал боловсруулах | Үйл ажиллагаа | Санал-1 | Газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар "Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам" батлагдсан. | Зайнаас тандан судлалын аргуудын талаар мэдээлэл цуглуулж, фото мониторингийн арга зүйн дутагдалтай болон давхардалд дүн шинжилгээ хийж, алдаа дутагдал, сайжруулах талаар Газрын даамлуудаас судалгаа авч, нэгтгэн ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх мэдээллийн санд хөгжүүлэлт хийх саналыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2/493 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2.3 | Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх шаардлагатай сумдын судалгааг гаргах, мөн багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Багаж, хэрэгслийн тоо | - | **Эхний хагас жилд:** Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх судалгааг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан байна. | Бэлчээрийн фото мониторингийн шинэчлэх шаардлагатай багаж хэрэгслийн судалгааг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 02/156 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй тул 15 сумын фото мониторингийн хээрийн судалгаа хийхэд шаардлагатай 1,7 сая төгрөгийн багаж хэрэгслээр (жин, метр, самбар) сумдын Газрын даамлуудыг хангаж хүлээлгэн өгсөн. | 100 |
| **3.1.3** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах** | **Үйл ажиллагаа** | **Төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгаа хийгдсэн тоо** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийсэн ажлын тайлан мэдээ** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, хянан баталгааны үр дүнг мониторингийн цахим системд оруулсан байна.** | **Аймгийн хэмжээнд 2024 онд газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх мэдэгдэх хуудсыг 226 иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлж, 118 иргэн, аж ахуй нэгжийн захиалгат хянан баталгааг хийлгэж 116 дүгнэлтийг баталгаажуулсан.** | **100** |
| 3.1.3.1 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | Захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо | 2023 онд нийт 53 тайлан, дүгнэлт баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:** Цахим системээр хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй алдаа, зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулсан байна. Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. **Жилийн эцэст:** Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. | Газрын мониторингийн цахим системээр 118 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан дүгнэлтийг хүлээн авч 116 дүгнэлт баталгаажуулсан. Батлагдсан заавар журмын дагуу хийгдээгүй, шаардлага хангаагүй 2 тайлан дүгнэлтийг буцаасан. Цахим системээр ирүүлсэн дүгнэлтүүдэд дүн шинжилгээ хийхэд хөрсний бохирдол доройтолд өртсөн нэгж талбар байхгүй байна. Захиалгат хянан баталгаа хийлгэсэн нэгж талбарын тоо өмнөх оноос 61-ээр өссөн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1.4** | **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх** | **Үйл ажиллагаа** | **Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан төслийн тоо** | **21 аймгийн 330 сумын 2022 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулсан байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.** | **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн оруулж, хэрэгжилтэнд системээр хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулсан байна.** | **15 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.** | **100** |
| 3.1.4.1 | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах | Үйл ажиллагаа | Бүх сум | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна.<br>Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 15 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт тавьж газрын даамлуудад тогтмол арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар цахим системээр дамжуулан 262 байршилд 866.55га газрыг иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлж, өмчлүүлж, ашиглуулсан ба төлөвлөгөөнд тусгаагүй газар олголт хийсэн зөрчил байхгүй болно.<br>Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн оруулсан. | 100 |
| 3.1.4.2 | Сумын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | 4 сургалт | - | Улиралд нэг удаа цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна.<br>Сургалт зохион байгуулсан тайлан мэдээг тухай бүр тайлагнасан байна. | Газрын даамлуудыг чадавхижуулах сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 27,28-ны өдрүүдэд танхимаар, 3 удаа цахимаар зохион байгуулж, арга зүйн заавар зөвлөгөө өгч мэдээ мэдээллээр тухай бүр хангаж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.3 | Монгол улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 2025 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | Жил бүр хийгддэг. | **Жилийн эцэст:** Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| 3.1.4.4 | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг гарган хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | - | **Жилийн эцэст:** Аймгийн хэмжээнд сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг 2024 оны 3-р улиралд багтаан баталгаажуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай тогтоолын төсөлд тусгах саналаа 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд дүгнэлт гаргуулах хүсэлтийг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2/489 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| **3.1.5** | **Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх** | **Үйл ажиллагаа** | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын тогтоол** | **Засгийн газрын тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан 3 газрын гэрээ гэрчилгээг олгох ажлын зохион байгуулсан.** | **Улсын тусгай хэрэгцээнд газрыг авах, гаргах асуудлын хэрэгцээ, шаардлагыг судлах, холбогдох судалгаа хийж, дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байна.** | **Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн саналыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.5.1 | Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Аймгийн ИТХ-ын тогтоол | Засгийн газрын хуралдааны 2021 оны 55 дугаар тэмдэглэл гарсан. | **Эхний хагас жилд:** Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн саналыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| **3.1.6** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн 2021 оны тайлан** | **Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан.** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлж газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна.** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэж хяналт тавин ажиллаж байна.** | **100** |
| 3.1.6.1 | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг сумдаас авч нэгтгэн, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайлан | Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайланг 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг хуульд заасан хугацаанд хүлээн авч нэгтгэн, дараа оны 01 сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| 3.1.6.2 | Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргах ажлын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн тайлан | - | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргасан байна. | 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргана. | 100 |
| **3.1.7** | **Салбарын архивын албан мэдээллийг бүрдүүлэн,** | **Үйл ажиллагаа** | **Хүлээлгэн өгсөн ажил** | **2023 онд 4 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн** | **Төрийн архивт хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн 4 ажлыг** | **2010-2014 оны 3 сумын өмчлөлийн газрын нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивт** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **сан хөмрөг үүсгэх, архивлах** | | | **авсан.** | **шалгаж акт үйлдэн хүлээн авна.** | **татан авч төвлөрүүлсэн. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 онд хөтлөгдсөн 60 баримтыг архивт хүлээн авсан.** | |
| 3.1.7.1 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авах | Үйл ажиллагаа | Үүсгэсэн хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд 4 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авсан. Нийт 11 хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивд хүлээн авсан, | **Эхний хагас жилд:** . Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон гэрээт ажлын хүрээнд хийж төрийн архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна.<br>Архивт хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж талбарын хувийн хэргийн судалгааг загварын дагуу гаргаж, 12 дугаар сарын 10-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2023 оны ХХНЖ-ын дагуу байнга хадгалах 29 хэрэг, түр хадгалах 24 хэрэг хөтлөгдөж байгаагаас байгууллагын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлагдсан баримт хүлээн авах хуваарийн дагуу байнга хадгалах 24 баримт, түр хадгалах 36 баримт бичиг нийт 60 хадгаламжийн нэгжийг бүртгэл хөтлөн байгууллагын архивт хүлээн авсан. | 100 |
| 3.1.7.2 | Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг сумдаас татан төвлөрүүлэх | Үйл ажиллагаа | Татан төвлөрүүлсэн нэгж талбарын хувийн хэргийн тоо | ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, зааварчилгааны дагуу нэгж талбарын хувийн хэргийн баримтыг цэгцэлсэн. | **Эхний хагас жилд:**<br>3 сумын 2010-2014 онд үүссэн өмчлөлийн газрын хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2022 онд 14 сумын 2003-2010 онд үүссэн 3949 өмчлөлийн газрын нэгж талбарын хувийн хэргийг хүлээн авсан.<br>Тайлант онд Өндөршил, Хулд, Эрдэнэдалай сумдын 2011-2014 онд үүссэн өмчлөлийн газрын нийт 661 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Жилийн эцэст:** 3 сумын 2010-2014 онд үүссэн өмчлөлийн газрын хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивт хүлээн авсан. | |
| **3.1.8** | **Хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **-** | **Хот байгуулалтын чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.** | **"Бага газрын чулууны аялал жуулчлал"-ын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон Дэлгэрцогт, Дэрэн сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах шатанд 70 хувьтай байна.** | **70** |
| 3.1.8.1 | Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан баримт бичгийн тоо | - | **Эхний хагас жилд:** "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д шинээр батлагдсан хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг оруулсан байна. | Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт болох 28.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулж батлуулсан бөгөөд ажлын гүйцэтгэл 70 хувьтай гүйцэтгэгч "Ланд Овнер" ХХК-ийн ажлын зохион байгуулалтаас шалтгаалж ажил удаашралтай байна. | 70 |
| 3.1.8.2 | Монгол Улсын Засгийн газрын 2023 ны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Зардлын хэмжээ | Улсын хэмжээнд 162 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Монгол Улсын Засгийн газрын 2023 ны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлтэй холбоотойгоор төлөвлөгөө боловсруулах даалгаврын төслийг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулан баталгаажуулж шаардагдах зардлыг | Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт 28.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан батлуулсан. Уг төлөвлөгөө магадлалын шатанд хянагдаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орон нутгийн төсөвт тусгах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | | |
| **3.1.9** | **Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **-** | **21 аймгийн 330 сумын мэдээлэл бүртгэгдсэн.** | **Улсын хэмжээнд барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний** | **Тус аймгийн 15 сумын “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд**<br>**- 1965 барилга байгууламж**<br>**- 344 ногоон байгууламж,**<br>**- 439 зам талбайн байршил**<br>**- инженерийн дэд бүтэц цахилгаан хангамжийн 3281 тулгуур бүхий 146.73 км 125 ширхэг агаарын шугам**<br>**- цахилгаан хангамжийн 2.49 км 2 ширхэг кабель шугам**<br>**- үндсэн дэд станцаас гадна АТП, КТП, КТПН-ийн 48 байрлалд дэд станц**<br>**- Дулаан хангамжийн халаалтын ашиглалттай 14 уурын зуух**<br>**- 270 ширхэг худаг, 487 ширхэг 11.19 км шугам**<br>**- Ус хангамжийн 414 ширхэг 23.42 км шугам,**<br>**- ус нөөцлөх 3 сан**<br>**- ус хангамжийн 2 насос станц**<br>**- 81 ширхэг ус хангамжийн гүний худаг**<br>**- улсын чанартай 2 авто замын 3 байрлал дахь бүртгэл, зураглал**<br>**- орон нутгийн чанартай 2 авто зам**<br>**- Сайхан-Овоо суман дахь 1 гүүр** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **- Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдад 4 ширхэг гүүрэн гарц, Ариутгах татуургын 402 худаг, ариутгах татуургын 643 ширхэг 12.14 км шугам**<br>**- Дэлгэрцогт, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай сумдын цэвэрлэх байгууламжийн зураглалыг**<br>**тус тус боловсруулж хот байгуулалтын кадастрын цахим системд бүрэн оруулж дууссан ба өгөгдөл мэдээллийг үе шаттайгаар нэмэгдүүлсэн.** | |
| 3.1.9.1 | Шинээр барих барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх | Үйл ажиллагаа | Системд бүртгэсэн мэдээллийн тоо | Бүх сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцийн мэдээлэл бүртгэгдсэн. | **Эхний хагас жилд:**<br>Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн мэдээллийг бүртгэсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийг мэдээллийг бүртгэсэн байна. | 2024 онд ашиглалтад орсон 13 барилга байгууламж, 4 тохижилт, ногоон байгууламж, 8 сумын цэцэрлэг, сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламж, Сайнцагаан сумын “Түмний хороолол” болон “Хаус хороолол”-ын гадна 1,8 км ариутгах татуургын шугам, Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн 2.25км урт 0,4кВт-ийн шугам, хүн оршин суудаг газраар өнгөрөх 10 хүртлэх кВт 63,6 км урттай цахилгаан дамжуулах инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зураглалыг гаргуулж Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. | 100 |
| 3.1.9.2 | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д өгөгдөл мэдээллийг бүрэн оруулж холбогдох журам, зааврын дагуу өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn /-д шинээр бүртгэгдсэн өгөгдөл, мэдээлэл | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/ хэрэглээнд нэвтэрсэн. | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д шаардлагатай өгөгдөл, мэдээлэл бүртгэгдэж холбогдох журам зааврын дагуу барилга, байгууламжийн бүртгэл, мэдээлэл хөтлөгдөж | 2024 онд “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-ээр хүсэлт илгээх талаар танилцуулга мэдээллийг үйлчлүүлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын албан хаагчдад тогтмол заавар зөвлөгөө өгч барилга байгууламж шинээр барих архитектур төлөвлөлтийн даалгавар олгох 12 хүсэлт, барилгын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системийн өдөр тутмын үйл ажиллагаа тогтмол хийгдсэн байна. | ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох 5 хүсэлт, барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа сунгуулах 1 хүсэлт, барилгын загвар зураг батлах 3 хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн. | |
| **3.1.10** | **Худалдан авах ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **1 Төлөвлөгөө, 2 тайлан, ажил үйлчилгээний тоо** | **Ерөнхий төлөвлөгөөнд туссан 12 ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, гэрээт ажлыг хүлээн авсан.** | **Ерөнхий төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөн туссан ажлууд бүрэн хэрэгжиж, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | **2024 онд тус байгууллага 7 аж ахуйн нэгж байгууллагатай худалдах, худалдан авах гэрээ байгуулан ажилласан.** | **100** |
| 3.1.10.1 | Байгууллагын 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | 1 Төлөвлөгөө, 2 тайлан | 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөө батлуулсан. | Худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулсан байна. Тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Тайлант онд цахилгаан эрчим хүч, цэвэр ус, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, дулааны эрчим хүч, түлш шатахуунаар хангагч байгууллагууд болон бараа, бичгийн хэрэгсэл нийлүүлдэг 7 байгууллагуудтай худалдах, худалдан авах гэрээ байгуулан хамтран ажилласан. | 100 |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.1** | **Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Тухай бүр** | **-** | | **Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал:**<br>**- Сул орон тооны захиалгыг ТАСЗ-д 4 удаа хүргүүлж сул орон тоо 9 байсныг 7 болгож бууруулсан.**<br>**- Төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 5 иргэнийг** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ТАСЗ-ийн тогтоолын дагуу холбогдох албан тушаалд томилж өнгөрсөн онд тус аймагт тусгай шалгалт зарлагдаагүйн улмаас үүссэн томилгооны зөрчил 4 байсныг бүрэн арилгасан.<br>- Тус байгууллагад ажиллаж байгаа 1 албан хаагчаас шилжин ажиллах хүсэлт ирүүлснийг Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтын дагуу шилжүүлэн томилж сул орон тоог нөхсөн.<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээрээ "А" үнэлгээтэй дүгнэгдсэн 12 албан хаагчийн ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв ахиулж, зэрэг дэв шинээр олгосон.<br>- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, -дүгнэн улирал бүр мөнгөн урамшуулал олгосон.<br>- Төрийн албаны тухай хууль болон "Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын шаардлага хангасан 5 албан хаагч Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.<br>- "Нээлттэй ажлын байр өдөрлөг"-т байгууллагын бүтэц орон тоо, хүний нөөц, албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа, боловсон хүчний эрэлт хэрэгцээ, сул орон тооны талаарх мэдээллийг видео хэлбэрээр бэлтгэж байгууллагын пэйж хуудсанд байршуулсан. Мөн сул орон тооны мэдээллийг гарын авлага хэлбэрээр боловсруулж, иргэдэд хүргэсэн.<br>- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хүний нөөцтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжилтийг байгууллагын фэйсбүүк хуудас, пэйж хуудас болон мэдээллийн самбарт олон нийтэд ил тод байршуулсан.<br>Албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх зүйлд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллаж байна.** | |
| 4.1.1.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | - | Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээрээ “маш сайн”, “хэвийн” үнэлгээтэй дүгнэгдсэн албан хаагчдын ажилласан жил, ур чадварыг харгалзан шаардлага хангасан нийт 12 албан хаагчийн (10 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 2 албан хаачид зэрэг дэв шинээр олгуулах) материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.<br>Төрийн захиргааны нийт 25 албан хаагчтайгаас 18 албан хаагч буюу 70 хувийг зэрэг дэвтэй албан хаагчид эзэлж байна. | 100 |
| 4.1.1.2 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | - | Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна<br>Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | - ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу тус байгууллагын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах ажлын байрны жагсаалтыг ТАСЗ-д 4 удаа хүргүүлж, сул орон тоо 9 байсныг 7 болгож бууруулсан.<br>Тус аймагт 6 сумын Газрын даамлын орон тоо сул байгаа ба Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтын дагуу Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд Газрын даамал албан тушаалын чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байна.<br>- Тус байгууллагад ажиллаж байгаа 1 албан хаагчаас шилжин ажиллах хүсэлт ирүүлснийг Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт болон “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу сул орон тоог нөхсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Орон нутагт салбарын боловсон хүчний нөөц бүрдүүлэх зорилгоор "Мэргэжил сурталчлах өдөрлөг" арга хэмжээг 2 дахь жилдээ санаачлан зохион байгуулж байна.<br>Сул орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/, пэйж хуудас болон мэдээллийн самбарт нийт 7 удаа шинэчлэн байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээллэсэн.<br>- 2024 онд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагч байхгүй болно. | |
| 4.1.1.3 | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" /2021-2025/-ыг баталсан. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг байгууллагын дотоод журам болон байгууллагын "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-тэй уялдуулан боловсруулж, албан хаагчдаар хэлэлцүүлэн 22 арга хэмжээг төлөвлөн байгууллагын даргаар 2024 оны 1 дүгээр улиралд батлуулсан.<br>Мөн албан хаагчдаас ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгаа, сургалтын хүрээнд сэтгэл ханамжийн судалгааг авч, ирүүлсэн 2 саналыг дээрх төлөвлөгөөнд тусгасан.<br>Дээрх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж албан хаагчдын тэтгэмж урамшуулал, дэмжлэг, тусламжид 160,4 сая.төг-ийг байгууллагын төсвөөс, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор 596,3 сая.төг-ийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, 756,7 сая.төг-ийг зарцуулсан байна. Тухайлбал:<br>- Улирлын урамшуулалд 73,5 сая.төг<br>- Оффисын барилгын тохижилт, гадна фассад, дээврийн засвар үйлчилгээнд нийт 339,3 сая.төг /ОНТ/<br>- 5-аас дээш жил ажилласан 14 албан хаагчдад тэтгэмж болох 85,8 сая.төг<br>- Тоног төхөөрөмж сайжруулахад 21 сая.төг /ОНТ/<br>- Ланд 300 маркын авто машин худалдан авахад 236 сая.төг /ОНТ/ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Дотоод журамд заасны дагуу албан хаагчдад тусламж, дэмжлэгт зориулж 1,1 сая.төг<br>2024 оны 11 дүгээр сард албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж түвшин нэмэгдсэн эсэхийг тодорхойлж дахин судалгаа авч дүгнэхэд сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 81 байсан нь 92 болж 11-ээр өссөн үзүүлэлттэй байна.<br>Дээрх төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний 02/235 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн ба жилийн эцэст төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн тайланг албан хаагчдад танилцуулсан. | |
| 4.1.1.4 | Салбарын хэмжээнд “Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Салбарын хэмжээнд Жэндерийн талаарх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний орон нутагт хэрэгжүүлэх боломжтой 9 арга хэмжээг хяналтад авч 100 хувь хэрэгжүүлсэн ба хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/203 дугаар албан бичгээр, жилийн эцсийн тайланг нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/528 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ болон ХББОСЯ-нд тус тус хүргүүлсэн.<br>2024 онд “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд **“Харилцан хүндэтгэж, тэгш оролцоог хангая”** уриаг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа харгалзах, жендэрийн талаарх ойлголтыг иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, төлөвшүүлэхийг зорьж байгууллагын пэйж хуудсанд жендэртэй холбоотой 5 мэдээлэл байршуулсан. Мөн аяны хүрээнд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг эсэргүүцэх, үүнийг таслан зогсооход нийгмийн ойлголт, хандлага, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдлэгийг нэмэгдүүлж эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх **“Нэг тэрбумаараа тэмцье”** эмэгтэйчүүдийн эрх чөлөөний алхалтад оролцож, эв санаагаа илэрхийлсэн. | |
| 4.1.1.5 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тоголцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчлэх | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | - | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна. | - Албан хаагчдын цалингийн сүлжээг тус байгууллагын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан.<br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар тус байгууллагад нийт 27 албан хаагч ажиллаж байгаа ба хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн системд албан хаагчдыг бүрэн бүртгэсэн.<br>Тайлант хугацаанд ажил эрхлэлтийн байдалд 7 удаа дотоод хяналтыг зохион байгуулсан ба өөрчлөлт орох бүрт мэдээллийг тухай бүр шинэчилсэн.<br>- Зэрэг дэв ахиулсан болон шинээр авсан нийт 12 албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэл<br>- Төрийн үйлчилгээний 2 ажилтанд ур чадварын нэмэгдэл<br>- Холбогдох хууль тогтоомжийн дагуу удаан жил, ажил хавсарсны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл<br>- Шинээр ажилтан томилох, чөлөөлөгдөх бүрт мэдээллийг системд оруулсан. | 100 |
| 4.1.1.6 | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх | Үйл ажиллагаа | Мэдээ, судалгааны тоо | - | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Тус байгууллагын хүний нөөцтэй холбоотой 8 төрлийн 13 удаагийн судалгааг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлсэн. Тухайлбал:<br>- Нийт албан хаагчдын тоон үзүүлэлт<br>- “Шүүр” ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний судалгаа<br>- “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу мөнгөн урамшуулал олгох албан хаагчдын нарийвчилсан судалгаа<br>- Сул орон тооны судалгаа<br>- Зөрчилтэй томилгооны судалгааг ГЗБГЗЗЕГазарт,<br>- ТАЗ-ийн 2021 оны зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний судалгаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Ажилласан байдлын судалгаа<br>- Зөрчилтэй томилгооны судалгаа<br>- Сул орон тооны судалгаа<br>- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт<br>Шилжин ажилласан албан хаагчдын судалгааг ТАСЗ-д тус тус хүргүүлсэн. | |
| **4.1.2** | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **12 удаа** | **-** | **Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна.** | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг Шилэн дансанд хугацаанд нь байршуулан ажиллаж байна. Хугацаа хоцорч оруулсан мэдээлэл байхгүй болно.** | **100** |
| 4.1.2.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Мэдээллийн тоо | - | Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж | Шилэн дансанд 171 мэдээлэл оруулахаас 151 мэдээллийг хууль журамд заасан хугацаанд байршуулсан.<br>Хугацаа болоогүй 20 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан байна. | | |
| **4.1.3** | **Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **1 төлөвлөгөө, 3 тайлан,** | **-** | **Төлөвлөгөө болон тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.** | **-“Хариуцлагатай газрын харилцаа” аяны хүрээнд газрын удирдлагын нэгдсэн системд иргэд хэрхэн хандах, үйлчилгээ авах талаар гарын авлагуудыг шинэчилсэн ба ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх 110 дугаарыг гарын авлага дээр байршуулж сурталчилсан.<br>- “Нэгдье” аяны хүрээнд салбарын онцлогийг харуулсан зурагт хуудсыг байгууллагын пэйж хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан ба хэвлэмэл хуудас болгон хэвлүүлж, олон нийтийн газар, худалдааны төвүүдийн үүдэнд нааж, олон нийтэд сурталчилсан.<br>-Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөний гүйцэтгэлийн дундаж 100 хувь ба хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 02/259 дүгээр албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т болон аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.** | **100** |
| 4.1.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах | Үйл ажиллагаа | Тайлангийн тоо | 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна<br>Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. | Авлигын эсрэг 2024 оны төлөвлөгөөг Авлигын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон ГЗБГЗЗЕГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж 4 зорилгын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн тус байгууллагын даргаар 1 дүгээр улиралд батлуулсан.<br>Төлөвлөгөөний гүйцэтгэлийн дундаж 100 хувь ба хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 02/259 дүгээр албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т болон аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.<br>Дээрх төлөвлөгөө, хэрэгжилтийг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn ○пэйж хуудас болон мэдээллийн самбарт тус | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүр 4 удаа байршуулсан ба Авлигатай тэмцэх газрын фэйсбүүк хуудсанд байршуулсан шторк, постер, мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудсанд 8 удаа түгээж олон нийтэд сурталчилсан. | |
| 4.1.3.2 | Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлэг гаргагчийн тоо | 2022 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулсан байна. | Тус байгууллагад ХАСХОМ-ийг 8 албан тушаалтан мэдүүлдэг ба мэдүүлгийг албан тушаалтнуудаас хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн систем болох www.meduuleg.iaac.mn сайтад бүртгэн баталгаажуулж, баталгааны хуудас ирүүлсэн бүртгэлийг хөтөлж гарын үсэг зуруулсан.<br>Тус байгууллагын албан тушаалтнуудын 2023 оны ХАСХОМ-1, ХОМ хураангүй, ХАСХОМ-3, ХАСХОМ-4, ХАС хураангүй тайлангуудыг програмаас гарган баталгаажуулж албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. | 100 |
| 4.1.3.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Албан тушаалтнуудаас тус байгууллагад 205 мэдэгдэл тайлбар гаргасан ба мэдэгдэл тайлбарыг хүлээн авч, тухай бүр www.iaac.meduuleg.mn сайтын ЭБАТ цэсний “мэдэгдэл тайлбар” хэсэгт бүртгэсэн.<br>Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол 3 гарсан ба зөрчил үүссэн нөхцөл байдлын талаар удирдах албан тушаалтнаас шийдвэр гаргуулж, баталгаажуулсан.<br>Барилга, байгууламж ашиглалтад оруулах комиссын гишүүд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллах болон албан тушаалтнууд гэрээ байгуулах зэрэгт мэдэгдэл тайлбар гаргаж хэвшсэн.<br>Тус байгууллагын албан хаагчид тендерт оролцох, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаанд оролцохдоо ашиг сонирхлын мэдэгдэх хуудсыг харьяа байгууллагуудад гаргадаг болно. | 100 |
| 4.1.3.4 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Нийтийн албанд томилогдохоор нэр | 2024 онд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагч байхгүй ба нэр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах | | | | дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | дэвшсэн тохиолдолд Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, ирүүлсэн дүгнэлтийн дагуу тухайн албан тушаалд томилдог. | |
| **4.1.4** | **Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал** | **78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан.** | **Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.** | **Бодлогын баримт бичгүүдийн тус байгууллагад холбогдох арга хэмжээг хяналтад авч, тогтоол шийдвэрийн бүртгэл хөтлөн ээнжүүлж, Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолуудын дагуу хугацаанд нь гаргаж аймгийн ЗДТГ болон ГЗБГЗЗЕГ-т тайлагнан, дүгнүүлдэг.** | **100** |
| 4.1.4.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | - | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна. | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолуудын дагуу хугацаанд нь холбогдох газруудад тайлагнасан ба аймгийн ЗДТГ-аас хуваарилсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ЗДҮАХ-ийн тус байгууллагад холбогдох заалтуудыг хяналтад авч хэрэгжилтийг сар бүр цахимаар тайлагнаж ажилласан.<br>ГЗБГЗЗЕГ-ын гэрээний хавсралт 52 зорилтын хүрээнд 112 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 99,5 хувь<br>Барилгын хөгжлийн төвийн гэрээний хавсралт 20 зорилгын хүрээнд 33 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь<br>Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө 10 зорилтын хүрээнд 30 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь<br>Барилга хот байгуулалтын сайдын тус аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хавсралт 77 арга хэмжээний хэргжилтийн дундаж 97,8 хувь, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ<br>ЗДҮАХ-ийг 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний тус байгууллагад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдолтой 6 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 96 хувь<br>ЗГҮАХ-ийг 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тус байгууллагад холбогдолтой 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 90 хувь<br>Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 20 заалтын хэрэгжилтийн дундаж 97,3 хувь<br>Монгол Улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тус байгууллагад холбогдолтой 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 93 хувь<br>Аймгийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгтэй холбогдолтой 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь<br>Дээрх бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 96,5 хувь ба өмнөх оны дундаж үзүүлэлтээс 0,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| **4.1.5** | **Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **380 тушаал, 280 гэрээ, 1 журам, 1 эмхэтгэл** | **-** | **Тушаал болон гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгож бүртгэсэн байна. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан байна. Эмхэтгэл бэлэн болсон байна.** | **Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд гарч буй аймгийн Засаг даргын захирамжийн төсөл, албан бичиг, тус байгууллагын даргын тушаалын төсөл болон Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн төлөвлөж, хяналт тавин ажилладаг.<br>Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой 62 тушаал, боловсон хүчний холбогдолтой 28 тушаал албажиж гарсан ба тушаалын хууль эрх зүйн үндэслэл, алдаа дутагдлыг ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хянуулж "тодорхой зөрчил илрээгүй, холбогдох хууль тогтоомжид нийцэж байна" гэсэн дүгнүүлт ирүүлсэн.<br>Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-д заасан өргөдлийн төрлүүдээр 17 төрлийн захирамжийн төслийг бэлдэж Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **болон сумдын Газрын даамлуудад файлыг хүргүүлсэн.** | |
| 4.1.5.1 | Газрын даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тушаалын төслийн тоо | 2023 онд 116 тушаал гарч албажсан байна. | Газрын даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | Тайлант хугацаанд Газрын даргын 90 тушаалын төслийг хууль эрх зүйд нийцүүлэн боловсруулж, байгууллагын даргаар албажуулсан байна.<br>Тушаалын хэрэгжилтэд Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн хяналт тавьдаг ба хэрэгжилт удаашралтай байгаа тушаалын холбогдох заалтыг хариуцсан албан хаагчдад танилцуулж, холбогдох арга хэмжээг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| 4.1.5.2 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, албажуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын тоо | - | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | Байгууллагын БНШК-ын бүрэлдэхүүн, дүрмийг боловсруулж байгууллагын даргын тушаалаар шинэчлэн баталсан.<br>Байгууллагын дотоод журмыг байгууллагын даргын 2022 оны А/11 дүгээр тушаалаар шинэчилж баталсан ба уг журмыг шинэчлэх эсэх талаар хамт олноор хэлэлцүүлэхэд хөдөлмөрийн харилцаанаас үүссэн асуудлууд болон жендэр, хүний эрхтэй холбоотой зохицуулалтууд тодорхой тусгагдсан тул энэ онд дахин шинэчлэх шаардлагагүй гэж шийдвэрлэсэн. | 100 |
| **4.1.6** | **Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлал** | **Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор журам шинэчлэн батлагдсан.** | **Журманд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.** | **Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ГЗБГЗЗГ-ын дарга болон аймгийн Засаг даргаар хянуулан гурвалсан гэрээг 2024 оны 01 дүгээр улиралд батлуулсан.<br>Барилгын хөгжлийн төвийн Захиралтай болон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 1 дүгээр улиралд тус тус батлуулсан.<br>Газрын удирдлагын хэлтэс болон Барилга хот байгуулалтын хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын бодлого, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон орон нутагт хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулж байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилтыг тодорхойлж, байгууллагын** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **даргаар 2024 оны 03 дугаар сард батлуулсан.**<br>**Дээрх гэрээнүүдийн хагас жилийн хэрэгжилтийг хавсралт тайлангуудын хамт батлагдсан загварын дагуу гаргаж холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж дүгнүүлсэн.**<br>**Жилийн эцсийн хэрэгжилтүүдийг нэгтгэхдээ шалгуур үзүүлэлтийн дагуу чанартай хэрэгжсэн эсэхд хяналт тавин холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж байна.** | |
| 4.1.6.1<br>- | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээний тоо | 2023 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж, биелэлтийг үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Албан хаагчид 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 дүгээр улиралд багтаан харьяа хэлтсийн даргаар батлуулсан.<br>Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэхдээ Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын дагуу үнэлгээний багийг байгууллагын даргын тушаалаар байгуулж, гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний үнэлгээ, мэдлэг чадварын үнэлгээ, албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадвар, багаар ажиллах чадвараар тус тус үнэлдэг.<br>2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр албан хаагчид гүйцэтгэсэн ажлын тайлангаа үнэлгээний багт илтгэж, үнэлүүлж дүгнүүлсэн ба энэ талаарх мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулсан.<br>Үнэлгээний мөрөөр албан хаагчдад мөнгөн урамшууллыг улирал бүр олгож, холбогдох журамд заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд зэрэг дэв олгох, ахиулах, шагнаж урамшуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг.<br>2024 онд 10 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 2 албан хаачид зэрэг дэв шинээр олгуулах санал хүргүүлж шийдвэрлүүлсэн. | 100 |
| **4.1.7** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдалтын хувь** | **-** | **Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон** | **15 сумын нэгж талбарын цахим болон цаасан хувийн хэргийг тулган шалгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгууллагын даргын тушаалаар** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.** | **байгуулж, батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.** | |
| 4.1.7.1 | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сумдын тоо | - | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Тус газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалаар Хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан 15 сумын нэгж талбарын цахим болон цаасан хувийн хэргийг тулган шалгах ажлыг зохион байгуулах удирдамжийг баталсан.<br>Батлагдсан удирдамжийн дагуу түүврийн аргаар 15 сумын нийт 792 нэгж талбарын цахим болон цаасан хувийн хэргийг тулган шалгах хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлттэй холбоотой шаардлага хангаагүй сканнердсан-83, буруу материал оруулсан-12, материал дутуу оруулсан-539 зөрчил илэрсэн нь Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журмын 9.3 дахь заалтыг зөрчсөн ба дээрх зөрчлийг бүрэн арилгуулсан. | 100 |
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | | **2021 онд 5 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.** | **Монгол Улсад орчин цагийн барилгын салбар үүсэж хөгжсөний түүхт 98 жилийн ой, Дундговь аймагт барилгын салбар үүссэний 63 жилийн ойг тохиолдуулан орон нутагт барилгын салбарт гарч буй өөрчлөлт, хөгжил дэвшил, төр болон барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор "Барилгын зөвлөгөөн-2024" үйл ажиллагааг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан.<br>Зөвлөгөөнд аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, ахмад барилгачид** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **болон тус аймагт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтнууд, инженер, техникийн ажилчид оролцож салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцож, аймгийн Барилгачдын холбооны удирдах зөвлөлийг шинээр сонгож, үйл ажиллагааг цаашид тогтмолжуулах талаар шийдвэрлэсэн.** | |
| 4.1.8.1 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан "Бүтээлч ажил"-ыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Бүтээлч ажлын тоо, Хэрэгжилтийн байдал | - | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө болон зарлагдсан бүтээлч ажлуудыг орон нутагтаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд орон нутагт шинээр санаачлан хэрэгжүүлэх 8 арга хэмжээг төлөвлөн байгууллагын даргаар батлуулж, төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн.<br><br>Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг "Газрын харилцааны мэдээлэл 70" сэтгүүлд оруулахаар материалыг хүргүүлсэн. | 100 |
| **4.1.9** | **Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.** | **Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | **2024 онд байгууллагын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөрт тусгагдсаны дагуу ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан тушаалтан, төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 1 албан хаагч хамрагдаж төгссөн ба албан хаагчид сертификатаа гардан авсан.<br>Тус байгууллагын нийт албан хаагчдаас төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 4 албан хаагч, төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 4 албан хаагч, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан ба төрийн захиргааны нийт албан хаагчдын 44 хувийг төрийн албаны мэргэшүүлэх** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **сургалтад хамрагдсан албан хаагчид ээлж байна.** | |
| 4.1.9.1 | Батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо | - | "Салбарын хэмжээнд байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | "Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө"-нд албан хаагчдаас ирүүлсэн саналыг тусган байгууллагын стратеги төлөвлөгөө, "Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөр", байгууллагын дотоод журамтай уялдуулан боловсруулж, байгууллагын даргаар 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан.<br>"Албан хаагчдын сургалтад хамрагдсан байдал" самбарыг ажиллуулж, албан хаагчдын сургалтад хамрагдалтын байдалд хяналт тавин, дүн шинжилгээ хийж, сургалтад хамрагдаагүй албан хаагчдыг хөгжүүлэх, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар төлөвлөн зохион байгуулан ажилладаг.<br>Тайлант хугацаанд танхимын 14, цахим 13, ТАЗ-ийн вебинар 12 удаагийн сургалт, бусийн 1 сургалт, ажлын байран дахь 13 удаагийн сургалт нийт 41 удаагийн сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан байна.<br>Гадаад сургалтад 1 албан тушаалтан хамрагдаж туршлага судалсан байна.<br>Мөн мэргэжил дээшлүүлэх хүсэлт ирүүлсэн 2 албан хаагч, мэргэшсэн инженерийн зэрэг горилох хүсэлт гаргасан 1 албан хаагчийн саналыг сургалтын төлөвлөгөөнд тусган сургалтын төлбөрийг орон нутгаас шийдвэрлүүлсэн.<br>Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 2024 оны төлөвлөгөөний хүрээнд 2,7 сая төгрөг зарцуулж, төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн ба хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 02/235 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.9.2 | Салбарын хууль тогтоомжийн хүрээнд ГХБХБГ-ын албан хаагчдыг болон сумдын газрын даамлуудыг мэргэжил арга зүгээр хангаж, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон салбарын хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын албан хаагчид, сумын газрын даамлуудад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүгээр хангаж ажилласан байна. | Тайлант хугацаанд тус байгууллагаас дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:<br>- Ажлын байран дээрх сургалтыг төлөвлөгөөний дагуу 7 хоног бүр зохион байгуулсан ба нийт 13 удаа зохион байгуулж, бүх албан хаагчид хуваарийн дагуу мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулсан.<br>- Газрын даамлуудыг чадавхижуулах, гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах сургалтыг 1 удаа танхимаар, чадавхжуулах, чиглэл өгөх 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан.<br>- “Барилгачдын зөвлөгөөн-2024” арга хэмжээнд орон нутгийн удирдлагууд, барилгын инженерүүд, тус аймагт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтнууд, инженер, техникийн ажилчид зэрэг нийт 50 гаруй хүн оролцсон.<br>ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан танхим болон цахим сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан ба сумдын Газрын даамлуудад тухай бүр цахимаар чиглэл өгч ажилласан. | 100 |
| **4.1.10** | **Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх** | **Үйл ажиллагаа** | **-** | **-** | **Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.** | **Байгууллагын үйл ажиллагааг цахим хуудас болон мэдээллийн самбар, байгууллагын FACEBOOK хуудсаар тогтмол сурталчилдаг.**<br>**Засгийн газрын 2022 оны 201-р тушаалаар батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу 98 арга хэмжээнээс тус байгууллагад хамааралтай 79 арга хэмжээг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудсанд иргэдэд ил тод, нээлттэйгээр байршуулсан.** | **100** |
| 4.1.10.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ | Салбарын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулж, | Байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/ болон facebook дахь хуудас /Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/, Дундговь аймгийн нэгдсэн веб хуудас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийг мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан. | нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | /www.dundgovi.gov.mn/-д салбарын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан сурталчилж байна.<br>Хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр 270 гаруй мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>Байгууллагын цахим хуудас болон facebook хуудсанд ГЗБГЗЗЕГ, аймаг орон нутгийн фэйсбүүк хуудсанд байршуулсан салбарын болон орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээлэл, шторкыг хуваалцаж иргэдэд сурталчилдаг.<br>"Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын нийтэд ил тод мэдээллэх 98 арга хэмжээнээс тус байгууллагад хамааралтай 79 арга хэмжээг байгууллагын сайт болон мэдээ, мэдээллийн самбарт ил тод байршуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хийгдсэн нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 98 хувьтай дүгнэгдэж, улсын хэмжээнд эхний хагас жилээр "Топ-10" байгууллагаар шалгарсан. | |
| **4.1.11** | **Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагааны зардал** | **Баримт бичиг** | **2022 онд 3600 албан бичиг, 500 өргөдөл, гомдол хүлээн авсан.** | **Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдолыг "Байгууллагын удирдлагын цогц цахим систем"-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.** | **Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд able систем болон төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp/-ийг ашигладаг.<br>ГЗБГЗЗГазраас ирсэн болон явсан бичгийг able системд бүртгэж, бусад байгууллагаас ирсэн болон тус байгууллагаас бусад байгууллага руу явуулсан бичиг, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг erp системд бүртгэдэг. Тайлант хугацаанд хугацаа хоцорч шийдвэрлэсэн албан бичиг болон өргөдөл гомдол байхгүй болно.** | **100** |
| 4.1.11.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Үйл ажиллагаа | Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан | 2024 онд 731 албан бичиг, 348 өргөдөл, гомдол хүлээн авч, | - Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох | Иргэдээс 348 өргөдөл гомдол ирсний 289 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 59 өргөдлийн шийдвэрлэх хугацаа болоогүй судалгааны шатанд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан бичгийн тоо, Өргөдлийн тоо, Тайлангийн тоо | 529 албан бичигт дугаар олгон холбогдох иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн. | албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>- Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>- Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.<br>- Өргөдөл, гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр тайлагнасан байна. | 731 албан бичиг ирснийг хяналтад авч 616 хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Хугацаа хоцорсон албан бичиг байхгүй.<br>529 албан бичиг явуулсан байна.<br>Ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлыг тухай бүр ABLE, ERP системд бүртгэж цахимжуулж, байгууллагын удирдлагад танилцуулж өдөрт нь холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьдаг. Хугацаа хоцорч шийдвэрлэсэн өргөдөл, хариутай албан бичиг байхгүй болно.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж, тайланг гарган аймгийн ЗДТГ-т хүргүүлэн ажилладаг. | |
| **4.1.12** | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хадгаламжийн нэгж** | **Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд 75 хадгаламжийн нэгж үүсгэсэн.** | **Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.** | **Байгууллагын 2023 онд хөтлөгдсөн 59 баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэлийг хөтөлсөн.** | **100** |
| 4.1.12.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | Хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд Байгууллагын хөтөлж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивласан. | 2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна.<br>2023 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж | 2023 оны ХХНЖ-ын дагуу байнга хадгалах 29 хэрэг, түр хадгалах 24 хэрэг хөтлөгдөж байгаагаас байгууллагын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр батлагдсан баримт хүлээн авах хуваарийн дагуу байнга хадгалах 24 баримт, түр хадгалах 36 баримт бичиг нийт 60 баримтыг бүртгэл хөтлөн байгууллагын архивд хүлээн авсан.<br>Архивын ерөнхий газрын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 дугаар тушаалаар “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт” батлагдсантай холбогдуулан ГЗБГЗЗЕГазар болон аймгийн Төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үүсгэн архивласан байна. | архиваас аргазүйн зөвлөмж авч 2024 оны ХХНЖ-ыг боловруулж, байгууллагын БНШК-ын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 01 дугаар хурлаар хянан хэлэлцүүлэн, 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан. | |
| 4.1.12.2 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:** Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна.<br>**Жилийн эцэст:** Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 100 |
| **4.2.1** | **Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх** | **-** | **Санхүүгийн хяналт шалгалтын дүн** | **Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод тайлагнаж ажилладаг.** | **Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.** | **2024 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн үйл ажиллагаа тогтвортой, холбогдох хууль журмын дагуу тайлагнагдаж, санхүүтэй холбоотой мэдээ тайлан, шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.** | **100** |
| 4.2.1.1 | Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.<br>Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна. | Тайлант онд 1,233,676,900 төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 2024 оны 03 сарын төсвийн тодотголоор 1,319,564,900 төгрөг болж 85,888,000 төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь цалингийн сан болон орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчид олгох тэтгэмж нэмэгдсэнтэй холбоотой. Мөн 2024 оны 09 сарын тодотголоор 1,285,784,000 төгрөг болж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | | 33,780,900 төгрөгөөр буурсан байна. Тухайн тайлант оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. 2024 онд үндсэн үйл ажиллагаанаас 130 сая төгрөгийн орлого төвлөрүүлж үйл ажиллагаандаа зарцуулахаас 12 сарын 1-ний байдлаар 68,456,043.16 төгрөгийн орлого төвлөрүүлж, 51,749,904.38 төгрөгийг өөрийн үйл ажиллагаандаа зарцуулаад байна. жилийн эцэс гэхэд орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллана. | |
| 4.2.1.2 | Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | 2023 оны санхүүгийн тайланг НББОУС-ын дагуу гарган Төрийн аудитын газраар баталгаажуулан ГЗБГЗЗГ болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Аудитаар санхүүгийн өөрчлөлтгүй дүгнэлт гарсан. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу гаргахад бэлдэж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 4.2.1.3 | Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна. | Өмнөх оны санхүүгийн тайланд 57,825,397.16 төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагатай, ямар нэгэн өр төлбөргүй тайлагнасан бөгөөд тайлант онд авлагыг барагдуулж 12 сарын 1-ны байдлаар ямар нэгэн өр авлага үүсээгүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1.4 | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна. | Байгууллагын бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын даргын 2024 оны 6 дугаар сарын 04-ны өдрийн А/17 дугаар тушаалаар эхний хагас жилийн тооллогын ажлыг зохион байгуулсан. Тооллогоор ямар нэгэн илүүдсэн дутагдсан хөрөнгийн зөрчил илрээгүй бөгөөд элэгдэлээрээ өртөгөө нөхсөн 00 төгрөгийн өртөгтэй цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглалтын хугацааг сунгах саналыг ГЗБГЗЗГ-т хүргүүлэн ажиллаж байна. Мөн элэгдэлээ бүрэн нөхөж цаашид ашиглах боломжгүй болсон 90,945,600 төгрөгийн өртөг бүхий авто тээврийн хэрэгсэлүүдийг актлах саналыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг бүрэн хийсэн бөгөөд тооллогоор илүүдсэн дутагдсан хөрөнгө гараагүй болно. | 100 |
| 4.2.1.5 | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн хугацааг хоцроохгүй байх. | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайланг сар улирлаар гарган холбох газруудад нь цаг хугацаанд нь бүрэн хүргүүлсэн.<br>Шилэн дансанд 171 мэдээлэл оруулахаас 151 мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж, хугацаа болоогүй 20 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулна. | 100 |

**Зорилтын тоо 52: 100 хувь - 51, 70 хувь -1 Дундаж хувь – 99,4**
**Арга хэмжээний тоо 112: 100 хувь - 111, 70 хувь-1 Дундаж хувь – 99,7**
**Гүйцэтгэлийн дундаж хувь 99,5**

**ХЭРЭГЖИЛТ ХЯНАСАН:**

ГАЗРЫН ДАРГА Э.ЧАГНААДОРЖ

**ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:**

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.БОЛОРЧИМЭГ